



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн "Замын Үүд НААУ" ОНӨХХК -ийн 2020 оны
санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Сайншанд сум
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Э.Батчимэг

Утас: 99032916

Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.03.19 № 4-6/302

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАМЫН-ҮҮД НААҮ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ө.НАРАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлэн ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлан дахь өмчийн дүн Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж баталгаажуулсан компаний дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс 1,552,402.8 мянган төгрөгөөр төгрөгөөр илүү байна.
- Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх орлого Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн борлуулалтын орлогын дүнгээс 23,399.1 мянган төгрөгөөр илүү байна.

Энэ нь үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-д "Албан татвар суутган төлөгч доор дурдсан үйл ажиллагааг

хэрэгжүүлнэ", 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж, бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,518,071.76	451,226.00
1.1.2	Дансны авлага	974,464.00	974,464.00
1.1.6	Бараа материал	19,134,412.00	23,631,192.60
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,626,947.76	25,056,882.60
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,977,066,426.00	2,634,721,984.34
1.2.2	Биет бус хөрөнгө	100,100,000.00	-
	Газар		99,875,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,077,166,426.00	2,734,596,984.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,098,793,373.76	2,759,653,866.94
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,013,451.00	7,900,872.00
2.1.1.3	Татварын өр	40,609,311.00	35,813,363.20
2.1.1.4	НДШ - ийн өглөг	15,955,719.95	57,781,287.30
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	60,578,481.95	101,495,522.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	60,578,481.95	101,495,522.50
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	4,603,894,247.92	4,603,894,247.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,565,679,356.11)	(1,945,735,903.48)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	(284,259,394.92)	(110,198,984.00)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	(1,281,419,961.19)	(1,835,536,919.48)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,038,214,891.81	2,658,158,344.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,098,793,373.76	2,759,653,866.94

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	638,012,875.82	520,677,455.60
2	Борлуулалтын өртөг	2,637,272.73	-
3	Нийт ашиг(алдагдал)	635,375,603.09	520,677,455.60
5	Хүүний орлого	678,685.73	-
8	Бусад орлого	1,148,588.19	396,884,653.40
10	Ерөнхий ба удирдлагын зардал	915,185,029.93	1,009,515,760.67
11	Санхүүгийн зардал	201,900.00	113,683.50
12	Бусад зардал	6,075,342.00	7,803,222.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		10,328,426.83
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(284,259,394.92)	(110,198,984.00)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(284,259,394.92)	(110,198,984.00)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(284,259,394.92)	(110,198,984.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	2020 оны 12-р сарын 31
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,317,397,859.00	(1,281,419,961.19)	3,035,977,897.81
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(277,420,366.00)		(277,420,366.00)
3	Залруулсан үлдэгдэл	4,039,977,493.00	(1,281,419,961.19)	2,758,557,531.81
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(284,259,394.92)	(284,259,394.92)
6	Өмчид гарсан өөрчлөлт	563,916,754.92		563,916,754.92
9	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,603,894,247.92	(1,565,679,356.11)	3,038,214,891.81
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(269,857,563.37)	(269,857,563.37)
11	Залруулсан үлдэгдэл	4,603,894,247.92	(1,835,536,919.48)	2,768,357,328.44
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(110,198,984.00)	(110,198,984.00)
17	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	4,603,894,247.92	(1,945,735,903.48)	2,658,158,344.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	685,917,384.65	573,292,034.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	685,917,384.65	518,593,012.00
	Татаас, санхүүжилтийн орлого		50,794,500.00
	Бусад мөнгөн орлого		3,904,522.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	767,104,313.11	572,558,879.76
	Ажиллагчдад төлсөн	371,802,793.00	366,632,155.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	87,748,973.59	18,255,720.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	93,333,562.60	78,987,924.00
	Ашиглалтын зардалд төлсөн	57,209,122.24	22,007,196.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		11,099,767.50
	Татварын байгууллагад төлсөн	70,391,770.84	49,856,552.20
	Бусад мөнгөн зарлага	86,618,090.84	25,719,565.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(81,186,928.46)	733,154.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	746,554.30	-
	Хүлээн авсан хүүний орлого	746,554.30	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	140,300,000.00	1,800,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	140,300,000.00	1,800,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(139,553,445.70)	(1,800,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,744,928.89	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,744,928.89	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,744,928.89)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(223,485,303.05)	(1,066,845.76)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,003,374.81	1,518,071.76
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,518,071.76	451,226.00

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

№	Үзүүлэлт / Зүйл анги тус бүрээр	2020 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Орлого	1,070,460,720	917,562,109	(152,898,611)	86
	Санхүүжилтийн орлого	739,260,720	486,695,800	(252,564,920)	66
	Төв талбайн авто зогсоолын орлого	80,000,000	29,631,920	(50,368,080)	37
	Автобусны орлого	105,000,000	11,716,642	(93,283,358)	11
	Цэвэр усны орлого	11,000,000	8,728,000	(2,272,000)	79
	Үйлчилгээний орлого	125,000,000	24,150,750	(100,849,250)	19
	Үйлчилгээний орлого /бункер/	2,000,000	-	(2,000,000)	-
	Журмын хашааны орлого	-	8,464,400	8,464,400	
	Түрээсийн орлого	4,200,000	-	(4,200,000)	-
	Бусад орлого/гэрлийн шонгийн төлбөр/	3,500,000	3,904,522	404,522	112
	Хүүгийн орлого	500,000	-	(500,000)	-
	ЗД-ын захирамжаар ҮХ авсан		344,270,075	344,270,075	
B	Зардал	939,035,332	1,027,761,093	88,725,761	109
	Цалин	490,734,000	366,632,000	(124,102,000)	75
	Шимтгэл	63,795,400	18,255,700	(45,539,700)	29
	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	384,505,932	642,873,393	258,367,461	167
3	Бараа материал худалдан авахад	55,000,000	35,957,424	(19,042,576)	65
4	Гэрэл цахилгаан, ашиглалтын зардал	18,922,000	22,007,196	3,085,196	116
5	Тээвэр шатахуун, тос масло	100,000,000	11,099,768	(88,900,233)	11
8	Нормын хувцас	-	8,680,000	8,680,000	
9	Автомашин сэлбэг хэрэгсэл	43,030,500	43,030,500	-	100
10	Гудамж гэрэлтүүлэг	32,551,300	32,551,300	-	100
11	ТӨГАҮ	18,685,700	18,685,700	-	100
12	Татварын байгууллагад	77,054,232	49,856,552	(27,197,680)	65
13	Төлбөр хураамж /ҮХХТ,Газрын татвар /	4,000,000	3,600,000	(400,000)	90
14	Аудитын баталгаажуулалт	2,500,000	2,500,000	-	100
15	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		8,566,408	8,566,408	
16	Тээврийн хэрэгслийн татвар	2,500,000	2,500,000	-	100
17	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	6,000,000	6,000,000	-	100
18	Үндсэн хөрөнгийн элэгдэл		371,198,397	371,198,397	
19	Сургалт мэргэжил дээшлүүлэх зардал	4,320,000	300	(4,319,700)	0
20	Албан томилолтын зардал	5,000,000		(5,000,000)	-
21	Тэмдэглэлт ой, арга хэмжээний зардал	3,780,000		(3,780,000)	-
22	Бичиг хэрэг шуудан холбооны зардал	8,508,200	8,508,200	-	100
23	Бусад үйл ажиллагааны зардалд	2,654,000	7,803,222	5,149,222	294
24	Үндсэн хөрөнгө хассаны гарз		10,328,427	10,328,427	
B	Ашиг	131,425,388	(110,198,984)	(241,624,372)	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Ө.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд орлогын дэлгэрэнгүй тайланг НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлоготой тулгах, санхүүгийн тайлангийн өмчийн дүнг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж баталгаажуулах, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоолж төлөвлөх, нягтлан бодох бүртгэлд тусгах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 03-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн захирал, Аудитор Э.Батчимэг, Ахлах аудитор Г.Энхтөр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмч, үүнээс Дорноговь аймгийн ИТХ 100 хувь эзэмшиж байна.

Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн хог тээврийн үйлчилгээ, нийтийн эзэмшлийн талбай гудамжны цэвэрлэгээ, авто машины зогсоолын болон дулаан эрчим хүчний үйлдвэрлэл, ариутгах татуурга, ус хангамж, иргэдийн үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, зорчигч тээвэрлэлт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас хяналт шалгалт ороогүй байна.

Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 520.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайланд засвар орж материаллаг байдлын түвшинг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 866.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 339.1 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.5	0.5	(1.0)
Авлага	0.9	0.9	-
Урьдчилгаа			-
Бараа материал	19.1	23.6	4.5
Үндсэн хөрөнгө	3077.3	2734.7	(342.6)
Нийт хөрөнгийн дүн	3098.8	2759.7	(339.1)
Өр төлбөр	60.6	101.5	40.9
Эздийн өмч	3038.2	2658.2	(380.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3098.8	2759.7	(339.1)

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.5 сая төгрөг болж 1.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 0.9 сая төгрөг нь эхний үлдэгдэл бөгөөд авлага дансны үлдэгдэлд 2014 онд үүссэн, он удаан жил болсон 0.9 сая төгрөгийг хувь хүнээс авах авлага байна.

Нийт авлага болох 0.9 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага эрсдэлтэй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23.6 сая төгрөг болж 4.5 сая төгрөгөөр өссөн нь эд хогшил нэмэгдэж, бараа материалаар зардал буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2734.7 сая төгрөг болж 342.6 сая төгрөгөөр буурсан нь 2020 онд 344.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан ба Засаг даргын захирамжаар 315.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч, аудитын явцад бүх үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг дахин тооцоолж 269.9 сая төгрөгөөр хуримтлагдсан элэгдлийг залруулсан.

Тайлант онд Дорноговь аймгийн ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 52 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар 4.3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 7 тээврийн хэрэгслийг худалдан борлуулах шийдвэр гарсан боловч худалдан борлуулах ажлыг зохион байгуулаагүй учир үндсэн хөрөнгөөс хасаагүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл 101.5 сая төгрөг болж 40.9 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын хэлтэст өгөх 57.9 сая төгрөг, татварын хэлтэст өгөх 35.8 сая төгрөг, ҮЭ-ийн хороонд 7.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2,658.2 сая төгрөг болж 380.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдал 110.2 сая төгрөг, хуримтлагдсан элэгдлийг өмнөх үеийн үр дүн рүү 269.9 сая төгрөгөөр залруулснаас шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дорноговь аймгийн "Замын Үүд НААҮ" ОНӨ ХХК-ийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор 2020 оны орлогын төлөвлөгөө, бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц орон тоо, ажиллагсдын цалингийн хэмжээг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,070.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,070.4 сая төгрөгөөр, ашиг / алдагдал -ыг 0.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 917.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,022.5 сая төгрөгийн зардал гарган, 104.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь төв талбайн зогсоолын орлого, автобусны орлого, журмын хашааны орлого, санхүүжилтийн орлогоос бүрдэж байна. Санхүүжилтийн орлого нийт орлогын 53 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого		1070.5	917.6	(152.9)	85.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт		331.2	486.7	155.5	147.0
2	Нийт зардал		1070.3	1027.8	(42.5)	96.0

3	Цэвэр ашиг, алдагдал		0.2	-110.2	(110.4)	
---	----------------------	--	-----	--------	---------	--

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 оны нэг удаа зохион байгуулж үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөгөө, ажилчдын орон тоо, цалинтай холбоотой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд төсөв баталж зарцуулаагүй байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 14 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 1,106.0 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	48.80	2	48.80	100
Нийт дүн	2	48.80	2	48.80	100

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,951.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 269.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1,106.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,947.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад хуримтлагдсан элэгдлийг 269.9 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байсныг өмнөх үеийн үр дүнд залруулсан.

ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАГН ШААРДЛАГА

1. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 14 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 1,106.0 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 7 дугаар зүйлийн 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байгууллагын даргын тушаалаар тооллогын комисс томилж тооллого хийж байгаа боловч тооллогын комисс үндсэн хөрөнгийн тооллогод голлон анхаарч бусад хөрөнгө, авлага, өр төлбөрийн тооллогыг хийж үр дүнг тооцож баримтжуулсан байдал хангалтгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу тооллогыг иж бүрэн хийж, үр дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Борлуулалтын орлогыг авлагын дансаар дамжуулан бүртгэдэггүй, борлуулалтын авлагын үлдэгдэл тайлагнаагүй байна. Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан авлагын бүртгэлийн бодлогыг тууштай мөрдөж ажиллах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан дахь өмчийн дүн компаний дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний дүнтэй тохирохгүй байна.

Энэ нь үнэлгээ батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Компаний өөрийн хөрөнгийн хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажуулаагүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Компаний тухай хуулийн дагуу өмчид гарсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж баталгаажуулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх орлого НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогын дүнгээс 23,399.1 мянган төгрөгөөр илүү байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Татварын тайлангаар орлогыг дутуу илэрхийлсэн нь нөхөн татварын тооцоо үүсэх, татварыг хугацаандаа төлөөгүйгээс торгууль, алданги төлөх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах. Төлбөрийн баримтыг борлуулалт хийсэн тухай бүр олгож ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан татвар төлөгчийн

нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно”, 17.3-т “Хөрөнгийн элэгдэл, хорогдлыг шулуун шугамын аргаар байгуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Эрсдэл:

Зардлын төсөв хэтрүүлэх хяналтгүй зардлын гүйлгээ хийх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тусгаж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	"Замын-Үүд НААУ" ОНӨХХК-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/2/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	"Замын-Үүд НААУ" ОНӨХХК		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайлан дахь өмчийн дүн компаний дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний дүнтэй тохирохгүй байна.	1,552.4	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ө.Нарантуяа Х.Азжаргал
2	Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх орлого НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогын дүнгээс 23,399.1 мянган төгрөгөөр илүү байна.	23.4	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ө.Нарантуяа Х.Азжаргал
3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй байна.	269.9	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Ө.Нарантуяа Х.Азжаргал
4	Шилэн дансны цахим хуудсанд 1,106.0 сая төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй байна.	1,106.2	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ө.Нарантуяа Х.Азжаргал
ДҮН		2,951.9			